

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2009 оны дугаар тогтоолын
хоёрдугаар хавсралт

**“НИЙСЛЭЛИЙН ТЭРГҮҮНИЙ ТАРИАЛАНЧ ХАМТ ОЛОН”
“НИЙСЛЭЛИЙН ТЭРГҮҮНИЙ ТАРИАЛАНЧ”
ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

Хөрс хамгаалах дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж эрчимжүүлэх, Нийслэлийн хэмжээнд газар тариалангийн салбарт нэгжээс хураан авах ургац, бүтээгдэхүүний чанар, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд идэвхисанаачлага гаргаж, тогтвортой өндөр амжилт үзүүлж байгаа болон нийгэмд оруулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хувь нэмрийг урамшуулахад энэхүү журмын зорилго оршино.

Нийслэлийн хэмжээнд газар тариалангийн үйлдвэрлэлийг үр дүнтэй эрхэлж, энэхүү журмын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан 3 хүртэл аж ахуйн нэгж, байгууллагыг “Нийслэлийн тэргүүний тариаланч хамт олон”-оор, 3 хүртэл иргэнийг “Нийслэлийн тэргүүний тариаланч” –аар жил бүр шалгаруулна.

“Нийслэлийн тэргүүний тариаланч хамт олон”, “Нийслэлийн тэргүүний тариаланч”-ийг шалгаруулах асуудлыг Нийслэлийн Засаг даргын саналыг өргөн барьсаны дагуу Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар шийдвэрлэнэ.

Хоёр. Шагналд тодорхойлох шалгуур үзүүлэлт

“Нийслэлийн тэргүүний тариаланч хамт олон”, “Нийслэлийн тэргүүний тариаланч”-аар шалгаруулах аж ахуйн нэгж, байгууллага, иргэн дараахь шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан байна. Үүнд:

а/ Аж ахуйн нэгж, байгууллага нь жил бүр усалгаагүй нөхцөлд малын тэжээлийн ургамал 50 га, усалгаатай нөхцөлд 25 га, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийг 10 га, иргэн нь төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийг 0.5 га-гаас доошгүй талбайд тус тус тариалалт хийж ургац авсан байна.

б/ Усалгаагүй талбайд тариалсан төмсний ургацын сүүлийн 3 жилийн дундаж ургац нь 100 цн-ээс доошгүй байна.

в/ Усалгаатай талбайд тариалсан төмсний ургацын сүүлийн 3 жилийн дундаж ургац нь 150 цн-ээс доошгүй байна.

г/ Хүнсний ногоо, жимс жимсгэний 1 га тутмаас хураан авсан ургацын сүүлийн 3 жилийн дундаж нь 140 цн-ээс багагүй байна.

д/ Малын тэжээлийн ургац нь усалгаагүй талбайд 20 цн-ээс, усалгаатай талбайд 50 цн-ээс доошгүй байх

е/ Сүүлийн 3 жил дараалан, жил бүр га тутмаас байцаа 200 цн-ээс, үндэс үрт ногоо 150 цн-ээс, сонгинолог ургамлыг 100 цн-ээс, хамгаалагдсан хөрсний 1 метр квадрат талбай тутмаас өргөст хэмх 15 кг, улаан лооль 10 кг-аас доошгүй ургац хураан авсан байх

ё/ Хамгаалагдсан хөрсний үйлдвэрлэл, усалгаатай газар тариаланг хөгжүүлэхэд тодорхой үр дүн гаргасан, хөрсийг элэгдэл эвдрэлээс хамгаалах, түүний үржил шимийг дээшлүүлэх, хог ургамлыг устгах шинэ арга технологийг нэвтрүүлсэн байна.

ж/ Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний үйлдвэрлэл эрхлэгчид нь эргэлтийн талбайгаа 100 хувь ашиглаж, дараа оны тариалалтад зориулан хүрэлцэхүйц хэмжээний чанар сайтай үр нөөцөлсөн байх

з/ Аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалт хийж, шинээр ажлын байр бий болгох, ажиллагсдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд тодорхой хувь нэмэр оруулсан байх

и/ Хураан авсан ургацын чанар нь улсын стандартын шаардлага хангасан байх

к/ Хугацаа хэтэрсэн, баталгаа алдсан өр, зээлгүй байх

л/ Үйлдвэрлэлийн осол гаргаагүй байх

м/ Татвар, хураамж болон газрын төлбөрийг хугацаанд нь төлсөн байх

Гурав. Тодорхойлолт бүрдүүлэх, шалгаруулах зарчим

3.1 Хороо, дүүргийн “Тэргүүний тариаланч хамт олон”, “Тэргүүний тариаланч” болсноос хойш нэгээс доошгүй жил амжилтаа тогтвортой хадгалан ажиллаж, энэхүү журмын шаардлага, шалнуур үзүүлэлтийг хангасан тариаланч хамт олон, тариаланчийг “Нийслэлийн тэргүүний тариаланч хамт олон”, “Нийслэлийн тэргүүний тариаланч”-аар шалгаруулахаар тодорхойлно

3.1.“Нийслэлийн тэргүүний тариаланч хамт олон”, “Нийслэлийн тэргүүний тариаланч”-аар шалгаруулах аж ахуйн нэгж, байгууллага, иргэний тодорхойлолт, холбогдох материалыг хорооны Засаг дарга нь хорооны Иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрийн хамт жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор багтаан дүүргийн Засаг даргын тамгын газарт ирүүлнэ.

3.2.Дүүргийн Засаг дарга хорооны Засаг даргын ирүүлсэн тодорхойлолт, холбогдох материалыг хянаж үзээд **хамгийн өндөр** амжилт гаргасан 3 хүртэлх аж ахуйн нэгж, байгууллага, 3 хүртэлх тариаланчийн тодорхойлолт, холбогдох материалыг жил бүрийн 12 дугаар сарын 30-ны дотор Нийслэлийн Хөдөө аж ахуйн газарт ирүүлнэ.

3.3.Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь хороо, Дүүргийн Засаг даргаас ирүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэний ажлын тодорхойлолт, баталгаажсан материалыг үндэслэн хамгийн өндөр ажлын үзүүлэлтээр нь байр эзлүүлж, шаардлагатай бол газар дээр нь шалгаж энэхүү журмын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангаса 3 хүртэлх аж ахуйн нэгж, байгууллагыг “Нийслэлийн тэргүүний тариаланч хамт олон”-оор, 3 хүртэлх иргэнийг “Нийслэлийн тэргүүний тариаланч”-аар шалгаруулах саналыг боловсруулан 1 дүгээр сарын 25-ны дотор Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулна.

3.5.“Нийслэлийн тэргүүний тариаланч хамт олон”, “Нийслэлийн тэргүүний тариаланч”-аар шалгаруулахаар тодорхойлоход дор дурдсан материалыг бүрдүүлнэ.

а/ Хорооны Иргэдийн Нийтийн Хурлын шийдвэр

б/ Хорооны Засаг даргын тодорхойлолт

в/ Дүүргийн Засаг даргын тодорхойлолт

г/ “Нийслэлийн тэргүүний тариаланч хамт олон”-ны товч анкет

д/ “Нийслэлийн тэргүүний тариаланч”-ийн товч анкет

е/ “Нийслэлийн тэргүүний тариаланч хамт олон”, “Нийслэлийн тэргүүний тариаланч”-ийн сүүлийн 3 жилийн ажлын үзүүлэлт

ж/ Харъяалагдах татварын байгууллагын сүүлийн 3 жилийн тодорхойлолт

з/ Нийслэлийн Хөдөө аж ахуйн газрын ажлын хэсгийн дүгнэлт

3.6.Бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн дүнд бусдаас худалдан авсан болон өр төлбөрт авсан бүтээгдэхүүнийг оруулж тооцохгүй.

Дөрөв. Шагнал олгох, гардуулах

4.1.“Нийслэлийн тэргүүний тариаланч хамт олон”, “Нийслэлийн тэргүүний тариаланч”-ийн шагнал нь тухайн аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд зөвхөн нэг удаа олгогдоно.

4.2. “Нийслэлийн тэргүүний тариаланч хамт олон”-оор шалгарсан аж ахуйн нэгж, байгууллагыг тус бүр 1,500,0 / Нэг сая таван зуун мянга / төгрөг, “Нийслэлийн тэргүүний тариаланч”-аар шалгарсан иргэн тус бүрийг 1,00,000 / Нэг сая / төгрөгөөр тус тус шагнана.

4.3. Энгэрийн тэмдэг, гэрчилгээнд шаардагдах хөрөнгийг мөнгөн шагналаас нь санхүүжүүлнэ

4.4. “Нийслэлийн тэргүүний тариаланч хамт олон”, “Нийслэлийн тэргүүний тариаланч”-ийн шагналыг билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгнийг тохиолдуулан Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Нийслэлийн Засаг дарга гардуулна.

“Нийслэлийн тэргүүний тариаланч хамт олон”,
“Нийслэлийн тэргүүний тариаланч” шалгаруулах
журмын хоёрдугаар хавсралт

“НИЙСЛЭЛИЙН ТЭРГҮҮНИЙ ТАРИАЛАНЧ”-аар тодорхойлогдож
байгаа тариаланчийн товч анкет

..... оны дугаар сарын-ны өдөр

1	Дүүрэг, хороо	
2	Эцгийн /эхийн/ нэр	
3	Нэр	
4	Төрсөн он, нас, хүйс	
5	Боловсрол	
6	Эзэмшсэн мэргэжил	
7	Ам бүлийн тоо	
8	Ажилласан нийт хугацаа, хийж байсан ажил	
9	Үүнээс газар тариалангийн салбарт ажилласан хугацаа	
10	Төр засгаас хэдэн онд ямар шагнал авч байсан	
11	Дүүргээс авч байсан шагнал	

“Нийслэлийн тэргүүний тариаланч хамт олон”,
“Нийслэлийн тэргүүний тариаланч” шалгаруулах
журмын нэгдүгээр хавсралт

“НИЙСЛЭЛИЙН ТЭРГҮҮНИЙ ТАРИАЛАНЧ ХАМТ ОЛОН”-оор тодорхойлогдож
байгаа тариаланч хамт олны товч анкет

..... оны дугаар сарын-ны өдөр

1	Дүүрэг, хороо	
2	Аж ахуйн нэгжийн нэр	
3	Гэрчилгээний дугаар, регистрийн дугаар	
4	Үйл ажиллагааны чиглэл	
5	Газар тариалангийн салбарт үйл ажиллагаа явуулсан хугацаа	
6	Үүнээс төмс, хүнсний ногоо тариалдаг талбайн хэмжээ	
7	Хамгаалагдсан хөрсний <u>үйлвэрлэл</u> эрхэлдэг талбайн хэмжээ	
8	Шинэ санаа, техник технологийг нэвтрүүлсэн эсэх	
9	Бусад	

“Нийслэлийн тэргүүний тариаланч хамт олон”,
 “Нийслэлийн тэргүүний тариаланч” шалгаруулах
 журмын гуравдугаар хавсралт

**“НИЙСЛЭЛИЙН ТЭРГҮҮНИЙ ТАРИАЛАНЧ ХАМТ ОЛОН”,
 “НИЙСЛЭЛИЙН ТЭРГҮҮНИЙ ТАРИАЛАНЧ” ШАЛГАРУУЛАХ
 АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ**

..... оны дугаар сарын-ны өдөр

Д/д	Үзүүлэлт	Онууд			Тайлбар
	ОНОНОН	
1	Тариалангийн эргэлтийн талбай га. Үүнээс:				
	-тарьсан талбай				
2	<u>Тарималын</u> төрөл				
3	Хураан авсан ургац тонн. Үүнээс:				
	-нөөцөлсөн үр				
	-захиалга, гэрээгээр болон зах зээлд борлуулсан ургац тонн.				
4	Нэг га-гийн ургац /тарьсан талбайд <u>цн-ээр/</u>				
5	Нийт <u>борлуулт</u> сая төг. Үүнээс:				
	-татварт /мянган төгрөгөөр/				
6	Ашиг /мянган төгрөгөөр/				
7	Ажлын байрны тоо				

Жич: Энэ хүснэгтэд зөвхөн сүүлийн 3 жилийн тариалангийн үзүүлэлтээ бичих ба бусад туслах аж ахуй, үйлдвэрлэл үйлчилгээний талаар хорооны Засаг Даргын тодорхойлолтонд дэлгэрэнгүй бичсэн байна.